



УЛААНБААТАР ХОТЫН
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР
ОНӨААТҮГ

Токиогийн 5 дугаар гудамж, 3 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976) 7015 7015
Цахим шуудан: usug1959@gmail.com
Цахим хуудас: www.usug.ub.gov.mn

2024.04.11 № 6/671

танай _____-ны № _____-т

Тодруулга

“А” ХХК-аас “Программ, лиценз нийлүүлэх” нэртэй, УСУГ/20240102027 тендер шалгаруулалтын дугаартай, Багц№3:Дотуур сүлжээний хяналт, хамгаалалтын лиценз нийлүүлэх тендер дээр дараах тодруулгыг хүссэн байна. Үүнд:

1.Багц№3:Дотуур сүлжээний хяналт, хамгаалалтын лиценз нийлүүлэх тендерт гарын авлагын талаар тодруулах хүсэлтэй байна. Гарын авлага нь юуны талаар байх вэ? лиценз суурилуулах тухай байх уу?

2.ТШЗ 19.1-ийн 2.Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна. (Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй) гэсэн шаардлага байна. Энэ шаардлагыг хэрхэн нотлох талаар тайлбарлаж өгнө үү гэсэн байна.

Тодруулгын хариу: “Программ, лиценз нийлүүлэх” нэртэй, УСУГ/20240102027 тендер шалгаруулалтын дугаартай нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичгийн

1.“III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА” хэсгийн “Багц№3:Дотуур сүлжээний хяналт, хамгаалалтын лиценз нийлүүлэх”-ийн техникийн тодорхойлолтын “2.Бүрдэл.” хэсэгт дурдсан гарын авлага гэдгийг тухайн лицензийг суулгах, тохиргоо хийх гарын авлага гэж ойлгоно.

2.ТШББ-ийн ӨХ-ийн ТШЗ 19.1-ийн “2.Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна.(Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй)” гэснийг ТШББ-ийн ӨХ-ийн ТШЗ 19.1-ийн “1.Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт

зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа ирүүлэх” гэсэн баримт бичгээр нотлох болохыг үүгээр мэдэгдэж байна.